



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/795

Улаанбаатар хот

### Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2003 оны хөтөлбөр батлах тухай 29 дүгээр тогтоол, 2010 оны хөтөлбөр батлах тухай 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2003 оны хөтөлбөр батлах тухай 160 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны журам батлах тухай 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Намрын ногоон өдрүүд-2014" нэгдсэн арга хэмжээний хүрээнд үржлийн шилмэл мал шалгаруулах "Шилмэл мал-2014" улсын үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулж, нийслэлийн шилмэл мал, тэжээвэр амьтны судалгааг гарган оролцуулахыг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

2. Үзэсгэлэн, худалдааг зохион байгуулахад шаардагдах 20 855 500 /хорин сая найман зуун тавин таван мянга таван зуун/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.

3. Нийслэлд "Шилмэл мал-2014" улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажилд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т. Бат-Эрдэнэд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ